



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 -ны өдөр

Дугаар А/07

Эрхэмтг

Г Аяныг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд-Аюулгүй орчин" аяныг зохион байгуулах үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Удирдамж төлөвлөөний дагуу үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтлийн тандалт хариуцсан мэргэжилтэн /Б.Отгон-Эрдэнэ/-д даалгасугай.
3. Үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг төсөл хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
01 дугаар сарын 16-ны өдрийн
16/2 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ХҮҮХЭД - АЮУЛГҮЙ ОРЧИН” СЭДЭВТ АЯНЫ УДИРДАМЖ

Үндэслэл:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод осол гэмтлээс урьдчилан сэргийлж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 25 хувиар зам тээврийн ослын нас баралтыг 50 хувиар бууруулах зорилт дэвшүүлэн ажиллахыг улс орнуудад зөвлөсөн.

Алсын хараа 2050-ын 2.2.14-д Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах, ажлыг үндсэн зорилтын нэгээр тодорхойлсон.

Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолд Осол гэмтлийг бууруулах арга хэмжээг жил бүрийн 1 дүгээр сарын 2, 3 дахь долоо хоногт тодорхой сэдвийн дор зохион байгуулах, энэ хүрээнд иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг хийж ажиллахыг үүрэг болгосон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээгээр осол гэмтэл, хүчирхийллийн улмаас дэлхий дээр 5 секунд тутамд 1 хүн, жил бүр нийт 5,8 сая хүн амь насаа алдаж, 600 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болж байна.

2022 онд Орхон аймгийн хэмжээнд 797 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэнээс 0-18 насны 208 хүүхэд осол гэмтэлд өртөж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байна.

0-18 насны хүүхдийн осол, гэмтлийг шалтгаанаар нь авч үзэхэд:

- Зам тээврийн осол- 64
- Уналт- 85
- Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн- 22
- Түлэгдэлт 23

Иймд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулах зорилгоор “ХҮҮХЭД- АЮУЛГҮЙ ОРЧИН” аянг зохион байгуулах шаардлагатай байна.

Зорилго:

- Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлж, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, зөв зохистой зан үйлийг төлөвшүүлэх, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд аж ахуй нэгж байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Зорилт:

1. Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил эрчимжүүлэх

2. Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, мэдлэг хандлагыг дээшлүүлэх
3. Салбар хоорондын хамтын ажиллагаа оролцоог нэмэгдүүлэн ажиллах

Хугацаа: 2023 оны 1 дүгээр сарын 24-ноос 2 дугаар сарын 24-ний хооронд

Хэрэгжүүлэгч байгууллага: Орхон аймгийн Эрүүл мэндийн газар – Нийгмийн эрүүл мэндийн төв

Хамтран зохион байгуулах байгууллага:

- Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар
- Жаргалант сумын Засаг даргын тамгын газар
- Боловсрол шинжлэх ухааны газар
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
- Цагдаагийн газар
- Онцгой байдлын газар
- Эрүүл мэндийн байгууллагууд

Аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Аяны удирдамжийг хүргүүлэх	01 сарын 24	ЭМГ-ын НЭМТ	<ul style="list-style-type: none"> - Баян-Өндөр сумын ЗДТГ - Жаргалант сумын ЗДТГ - ЭМБ - БШУГ - ГБХЗХГ - ОБГ - ЦГ
2	Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр насны онцлогт тохирсон цахим гарын авлага бэлтгэх	01 сарын 24 02 сарын 20	ЭМГ-ын НЭМТ, Цагдаагийн газар	
3	Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	01 сарын 24 02 сарын 20	ЭМГ, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, ГБХЗХГ, ЦГ, ОБГ, БШУГ, ЭМБ	Аж ахуй нэгж байгууллага, иргэд
4	Бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулах	01 сарын 24 02 сарын 20	БШУГ	ГБХЗХГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, ОБГ, ЦГ, БОЭТ

5	Хүүхдийг осол гэмтэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр иргэдэд зөвлөмж, мэдээлэл өгөх	02 сарын 08	ЭМГ, ЦГ	ОБГ, БШУГ, БОЭТ, ГБХЗХГ
6	"Хүүхэд-аюулгүй орчин" сэдэвт уриалга зохион байгуулах	01 сарын 24 02 сарын 20	ЭМГ	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, ЦГ, ОБГ, БШУГ, БОЭТ, ЭМБ
7	Хүүхдийг осол гэмтлээс сэргийлэхэд эрүүл аюулгүй орчинг дэмжих талаар өдөрлөг зохион байгуулах	01 сарын 24 02 сарын 20	ГБХЗХГ	Аж ахуй нэгж байгууллага, иргэд
8	Хамгаалалтын бүс, малгай, хүүхдийн хамгаалах суудлын хэрэглээг хэвшүүлэх талаар жолооч, зорчигчдод зориулсан мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явуулах	01 сарын 24 02 сарын 20	ЦГ-ЗЦТ	Аж ахуй нэгж байгууллага, иргэд
9	Ахуйн орчин дахь осол, гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх судалгаа авах, зөвлөмж өгөх	01 сарын 24 02 сарын 20	ЭМГ	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ
10	Төрийн байгууллагуудын хүүхдийн ерөөний судалгааг гаргах	01 сарын 24 02 сарын 20	ЭМГ	Байгууллагуудын эцэг эхийн зөвлөл, Аж ахуй нэгж байгууллага
11	"Хүүхэд-Аюулгүй орчин" сэдэвт аяны тайланг ЭМГ-т ирүүлэх	02 сарын 27	ЭМГ	

Хүлээгдэж буй үр дүн:

1. Хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааны ажил эрчимжинэ.
2. Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр мэдлэг, хандлага дээшилнэ.
3. Салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоо нэмэгдэнэ.
4. Хүүхдийн осол гэмтлийн шалтгаант өвчлөл, эндэгдлийн тоо буурна.

ХЯНАСАН

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

A. Shumir

А.ГАНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН

НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,
ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТ, ОСОЛ ГЭМТЛИЙН
ТАНДАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

B. Otgon-Erdene

Б.ОТГОН-ЭРДЭНЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
.... дугаар сарын ...-ны өдрийн
.... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**"ХҮҮХЭД-АЮУЛГҮЙ ОРЧИН"-ЫГ ЗОХИОН ЯВУУЛАХ
СУРТАЛЧИЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/
Шагнал урамшуулал					
1.	Лого	Ширхэг	4	5 000	20 000
2.	Цагаан самбар	Ширхэг	1	59 500	59 500
3.	Арилдаг маркер	Ширхэг	1	4 500	4 500
Нийт дүн 79 500					

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН : НБТЧОГТХМ

Б.Отгон-Эрдэнэ

ТӨСӨВ ХЯНАСАН: ССБМНБА

Н.Чулуун-Эрдэнэ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
08 дугаар сарын 26-ны өдрийн
1/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**"ХҮҮХЭД-АЮУЛГҮЙ ОРЧИН"-ЫГ ЗОХИОН ЯВУУЛАХ
СУРТАЛЧИЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/
Шагнал урамшуулал					
1.	Лого	Ширхэг	4	5 000	20 000
2.	Цагаан самбар	Ширхэг	1	59 500	59 500
3.	Арилдаг маркер	Ширхэг	1	4 500	4 500
Нийт дүн 79 500					

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН : НБТЧОГТХМ *Б.Отгон-Эрдэнэ* Б.Отгон-Эрдэнэ

ТӨСӨВ ХЯНАСАН: ССБМНБА *Н.Чулуун-Эрдэнэ* Н.Чулуун-Эрдэнэ